



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/Ч/5

Арвайхээр сум


**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймаг байгуулагдсан тэмдэглэлт өдрийг угтан, жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Миний-Өвөрхангай” аяныг 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 18 өдөр хүртэл зохион байгуулж, зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан 3,800,000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

**6224 11 0103**

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 27 -ны өдрийн 1195 дугаар захирамжийн хавсралт



“МИНИЙ ӨВӨРХАНГАЙ” АЯНЫ ЗАРДАЛ

д/д	Чиглэл	Хамрах хүрээ (Ангилал)	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Миний Өвөрхангай” сэдэвт хичээл заах	СӨББ	Хичээл бэлтгэх, бичлэг хийх зардал	1	325,000	325,000
	“Миний Өвөрхангай” сэдэвт хичээл заах	Бага анги		1	325,000	325,000
	Өвөрхангай аймгийн үүсэл, түүх” сэдэвт хичээл заах	Дунд анги		1	325,000	325,000
	Өвөрхангай аймгийн байгалийн нөхцөл” сэдэвт хичээл заах	Ахлах анги, Политехник коллеж		1	325,000	325,000
2	Илтгэлийн уралдаан	ЕБС, СӨББ, Политехник коллежийн багш нар	I байр	3	350,000	1,050,000
			II байр	3	250,000	750,000
			III байр	3	110,000	330,000
			Тусгай байр	3	85,000	255,000
			Жааз	12	9,500	115,000
Нийт						3,800,000